Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Тайлант онд Засгийн газрын 2024 оны 3 дугаар сарын 27 ний өдрийн 128 дугаар тогтоолоор албан хаагчдын цалин нэмэгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүргийг Аймгийн ЗДТГ-ын Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хэрэгжүүлдэг бөгөөд 2024 онд дотоод аудитын хяналт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Овоо сумын ЗДТГ нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баян-Овоо сумын ЗДТГ нь 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3 дах заасан УНББОУС-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 529,392.9 мянган төгрөг буюу 25.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|----------------|-----------------|-------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 175,045.0 | 422,727.7 | 247,682.7 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 123.7 | 177,000.0 | 176,876.3 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 174,921.3 | 245,727.7 | 70,806.4 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,897,310.9 | 2,356,021.1 | 458,710.3 |
| Үндсэн хөрөнгө | 2,803,715.8 | 3,438,204.3 | 634,488.5 |
| Хуримтлагдсан элэгдэл | (906,404.9) | (1,082,183.2) | (175,778.3) |
| Нийт хөрөнгө | 2,072,355.9 | 2,778,748.8 | 706,392.9 |
| Өр төлбөр | 542.8 | 25,463.7 | 24,920.8 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 2,071,813.1 | 2,753,285.2 | 681,472.1 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 2,072,355.9 | 2,778,748.8 | 706,392.9 |

Бараа материалын дансны үлдэгдэл 245,727.7 мянган төгрөг болж өмнөх оноос 70,806.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд бусад хангамжийн материал дансанд 429,797.0 мянган төгрөгийн ОНХС болон хандиваар ирсэн өвс, малын тэжээл зэргийг орлогод авсан нь материалын данс 70,806.4 мянган төгрөгөөр нэмэгдэхэд голлох нөлөө үзүүлжээ.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 228,557.2 төгрөгийн бараа материал, үнэ төлбөргүй 452,578.7 мянган төгрөгийн бараа материалыг тус тус авч нийт 681,135.9 мянган төгрөгөөр орлогод бүртгэж 536,291.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж 74,037.5 мянган төгрөгийн бараа материалыг акталж зарлагдсан байна.

Тайланд онд ЗДТГ-ыг даргын 2024 оны 5 дугаар сарын 13-ний өдрийн А/09 дугаар тушаал, Сумын онцгой комиссын 11 дүгээр сарын 25-ний өдрийн 10 дугаар шийдвэрүүдээр нийт 72 нэр төрлийн 2612 ш 74,037.5 мянган төгрөгийн бараа материалыг акталж зарлагдсан байна. Үүнд Аж ахуй материалын дансанд бүртгэлтэй нийт 46,400.0 мянган төгрөгийн 2022 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн сумын урд хашсан талбайд хийсэн 2 хиймэл нуур, суулгац, шонхор шувууны суултуур, Бусад хангамжийн материал дансанд бүртгэлтэй 4,400.0 мянган төгрөгийн малын тэжээл зэрэг хөрөнгүүд голлох нөлөө нөлөө үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,438,204.3 мянган төгрөг болж 634,488.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Тайланд онд төсвийн хөрөнгөөр 497,679.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан нь үндсэн хөрөнгө данс өсөхөд голлох нөлөө үзүүлсэн байна. Үүнээс: Урсгал засвар хийж 247,929.0 мянган төгрөгөөр хөрөнгийн сайжруулалт хийсэн байна.

Хүснэгт 2. Төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгийн жагсаалт

/мянган төгрөгөөр/

| Үндсэн хөрөнгийн нэр | Тоо | Дүн | Шийдвэр |
|--------------------------|-----|----------|---|
| Dell Optiplex суурин ком | 1 | 2,299.9 | ЗДТГ-ын даргын 2024 оны 4 дүгээр сарын 26-ний өдрийн А/09 дугаар тушаал. |
| Dell SE2422H monitor | 1 | 619.9 | |
| Dell latitude НӨҮТБҮҮК | 2 | 5,999.8 | |
| HP Laserjet Prk принтер | 2 | 1,079.8 | |
| Төмөр хайс | 329 | 16,285.5 | ЗДТГ-ын даргын 2024 оны 6 дугаар сарын 12-ний өдрийн А/05 дугаар тушаал. |
| Хаалга | 2 | 770.0 | |
| Пост машин | 1 | 1,500.0 | ЗДТГ-ын даргын 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/15 дугаар тушаал |
| Камер /хэсгийн хороо/ | 4 | 946.0 | ЗДТГ-ын даргын 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн А/06 дугаар тушаал. |
| Буйдан | 1 | 950.0 | Сумын засаг дарга Энх цоо хишиг ХХК тай байгуулсан 2024 оны 10 дугаар сарын 10-ний өдрийн 51 дугаартай Цэцэрлэгийн тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээний дагуу |
| Дрож | 16 | 5,600.0 | |
| Интернэт | 1 | 3,300.0 | |
| Хивс | 55 | 6,875.0 | |

Баян-овоо сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|---------------------------------|-------|-----------|---|
| Шатны резин | 1 | 3,275.0 | |
| Гагнуурын аппарат | 1 | 450.0 | ЗДТГ-ын даргын 2024 оны 09 дүгээр сарын 10-ний өдрийн А/18 дугаар тушаал |
| Мотоцикль | 5 | 20,000.0 | Сумын Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 07-ний өдрийн А/98 дугаар захирамж |
| Бохирын цооног, холболтууд | 1 | 19,800.0 | 2024 оны 10 дугаар сард Хаш тэргүүн констракшнтай гэрээ байгуулан 19,800.0 мянган төгрөгөөр бохирын цооног хийлгэсэн. ЗДТГ-ын даргын 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/24 дугаар тушаалаар хөрөнгө зарцуулсан |
| Хөв цөөрөм 2250 м3 камержуулалт | 1 | 160,000.0 | Сумын засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 28- ний А/102 дугаар захирамжаар зарцуулсан. |
| Нэгдсэн конторын барилга | 1 | 12,800.0 | 2024 оны 9 дүгээр сард иргэн Ууганбаяртай гэрээ байгуулан 12.800.0 мянган төгрөгөөр дээврийн хар цаас хийсэн нь хөрөнгийн сайжруулалт хийсэн. ЗДТГ-ын даргын 2024 оны 9 дүгээр сарын 18-ний өдрийн 18 тугаар тушаалаар хөрөнгө зарцуулсан |
| Нэгдсэн конторын барилга | 1 | 1,050.0 | |
| Хүүхдийн цэцэрлэгийн барилга | 1 | 214,079.0 | Ерөөх нэмэх ХХК 2023 онд их засвар гүйцэтгэх тэндэрт шалгарч 2023 оны 12 дугаар сарын 06 ний өдөр Сумын засаг даргатай 38 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 2024 онд гүйцэтгэж ажлыг хүлээж авсан байна. |
| Цагдаагийн кабоны барилга | 1 | 20,000.0 | Сумын Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/98 дугаар захирамжаар хөрөнгө зарцуулсан. |
| Нийт | 428.0 | 497,679.9 | |

Тайлант хугацаанд өр төлбөр 24,920.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 131/ГХ/2024/00105, 131/ГХ/202300761 дугаар шийдвэрүүдийн дагуу 2 аж ахуй нэгжид 177,000.0 мянган төгрөгийн өр үүсэж тайлант хугацаанд 158,240.0 мянган төгрөгийн өр төлбөрийг төлж барагдуулсан нь өр төлбөр өсөхөд голлох нөлөө үзүүлсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,753,285.2 мянган төгрөг болж мянган төгрөг болж 681,472.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан 681,472.1 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн 1,378,146.7 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоор 1,000.0 мянган төгрөг, нийт зардлыг 1,379,146.7 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Баян-Овоо сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 09/01 дүгээр тогтоолоор сумын төвийг баталж Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн А/113 дугаар захирамжаар төсвийн хуваарийг 1,379,146.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд Засаг даргын А/47, А/40 дүгээр захирамжуудаар төсвийн хуваарьт 2 удаа зохицуулалт хийсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд орон нутгийн төсвийн санхүүжилтээр 1,846,457.6 мянган төгрөг, өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоос 200.0 мянган төгрөг нийт 1,846,657.6 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд зарцуулж 12,353.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

| Хөтөлбөр арга хэмжээний код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | /мянган төгрөгөөр/ Зөрүү | |
|-----------------------------|-------------------------------------|-------------|-------------|--------------------------|--------|
| | | | | Дүнгээр | Хувь |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 1,358,985.6 | 1,248,870.7 | 110,114.89 | 91.90 |
| 80106 | Баг, хорооны үйл ажиллагааны зардал | 170,210.3 | 138,034.6 | 32,175.68 | 81.10 |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 5,000.0 | 4,800.0 | 200.00 | 96.00 |
| 81102 | Орон нутгийн нөөц хөрөнгө | 133,500.0 | 121,344.3 | 12,155.70 | 90.89 |
| 81701 | Байгаль орчныг хамгаалах, нөхөх | 180,000.0 | 180,000.0 | - | 100.00 |
| 82212 | Хур хог хаягдал, орчны бохирдол | 11,020.7 | 11,000.0 | 20.70 | 99.81 |
| 82310 | Гамшгаас сэргийлэх сургалт | 141,700.0 | 130,254.6 | 11,445.45 | 91.92 |
| Нийт | | 2,000,416.6 | 1,834,304.2 | 166,112.4 | 91.7 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 54,395.5 мянган төгрөгийн санхүүжилт орж ирж гүйцэтгэлээр 48,382.0 мянган төгрөгийг зарцуулж 6,013.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баян-Овоо сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн 12/01 захирамжаар баталсан Баян-Овоо сумын 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ЗДТГ-нь 2024 онд шатахуун бэлтгэн нийлүүлэгчийг сонгох шалгаруулах 26,400.0 мянган төгрөгийн төлөвлөгөө багтсан байна.

Тайлант онд ЗДТГ нь шууд шатахуун худалдан авалтыг НИК ХХК тай шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

Баян-Овоо сумын Засаг дарга Ерөөл нэмэх ХХК-тай 2024 оны 10 дугаар сарын 28-ний өдөр байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас санхүүжүүлэх “Байгаль орчин, ан амьтан хамгаалах камержуулалд хийх, хөв цөөрөм байгуулах” ажлыг гүйцэтгэх 160.0 сая төгрөгийн шууд гэрээ байгуулсан боловч Баян-Овоо сумын ЗДТГ ийн хөрөнгөнд бүртгэлтэй хуучин цэцэрлэгийн барилгын их засварын ажилд зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь ТБОНӨ-ийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31.1 "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна", МУ-ын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны 02 дугаар тогтоолд заасан "Шууд худалдан авах барааны төсөвт өртгийн дээд хязгаар" -ын дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй шууд гэрээ байгуулсан, гэрээний мөнгийг зориулалт бусаар зарцуулсан шинж чанарын хувьд материаллаг тул Сөрөг дүгнэлт өгөх үндэслэл болно.

Мөн Ерөөл нэмэх ХХК-тай 2024 оны 10 дугаар сарын 28-ний өдөр байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас санхүүжүүлэх “Байгаль орчин, ан амьтан хамгаалах камержуулалд хийх, хөв цөөрөм байгуулах” ажлыг гүйцэтгэх 160,000.0 мянган төгрөгийн гэрээг Шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй байна.

Энэ асуудлыг Баян-Овоо сумын Засаг даргын 2025 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн 63 дугаартай албан бичгээр Авлигатай тэмцэх газар шалгуулахаар хүсэлт хүргүүлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Овоо сумын ЗДТГ нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Даваадорж гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Овоо сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан 2,000,416.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 30,006.2 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 19,504.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж тогтмол зардлын 83 хувийг зарцуулж 12,486,355.1 мянган төгрөгийг хэмнэж өр авлага үүсгээгүй ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаас Шилэн дансны тухай хуулийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан мэдээлбэл зохих 53 гүйлгээний 2,783,158.2 мянган төгрөгийн мэдээлэхээс 8 гүйлгээний 117,682.1 мянган төгрөгийн гүйлгээ мэдээлээгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж “Хязгаарлалттай дүгнэлт” авсан байна. Аудитаар 181,162.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 2,449.0 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт, 176,921.3 зөрчлийг арилгах 5 албан шаардлага, 2,792.4 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 албан шаардлага өгсөн байна.

Төлбөрийн актыг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2024 оны 06 дугаар сарын 11-ны өдрийн 76 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|-----------|---------|-----------|------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 1 | 2,792.0 | 1 | 2,792.0 | 100% |
| Төлбөрийн акт | 1 | 413.3 | 1 | 413.3 | 100% |
| Албан шаардлага | 1 | 174,921.3 | 1 | 174,921.3 | 100% |
| Албан шаардлага | 1 | 2,000.0 | 1 | 2,000.0 | 100% |
| Төлбөрийн акт | 1 | 200.2 | 1 | 200.2 | 100% |
| Төлбөрийн акт | 1 | 435.0 | 1 | 435.0 | 100% |
| Төлбөрийн акт | 1 | 1,400.0 | 1 | 1,400.0 | 100% |
| Нийт дүн | 1 | 182,161.8 | 1 | 182,161.8 | 100% |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар 45,000.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй хадлангийн трактор Баян-Өлгий аймгаас ирээгүйгээс 2024 оны үндсэн хөрөнгийн тооллогод тоологдоогүй байна. Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй хадлангийн тракторыг дараагийн аудитаар анхаарч авч үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 177,000.0 мянган төгрөгийн 1 алдаа илэрснээс аудитын явцад залруулав.

Үүнд: Баянхонгор аймаг дахь Сум Дундын Иргэний Хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 10 дугаар сарын 26-ний өдрийн 131/ШШ2023/000799 дугаар шүүгчийн захирамжаар 47,000.0 мянган төгрөг, 2023 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн 131/ШШ2024/00004 дугаар шүүхийн шийдвэрээр 130,000.0 мянга нийт 177,000.0 мянган төгрөгийг хариуцагч Баян-Овоо сумын Засаг дарга, Засаг даргын тамгын газраар төлүүлэхээр гарсан байна.

Шүүхийн шийдвэрт тусгагдсан нийт 177,000.0 мянган төгрөг нь Засаг даргын тамгын газрын дансанд орж ирээгүй, төсвөөс гадуур зарцуулагдсан, ямар эх үүсвэрт зарцуулсан тодорхойгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд 177,000.0 мянган төгрөгийг авлагаар бүртгэж залруулав.

Аудитаар нийт 502,349.7 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс 502,349.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Албан шаардлага

5.1.1 Баянхонгор аймаг дахь Сум Дундын Иргэний Хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 10 дугаар сарын 26-ний өдрийн 131/ШШ2023/000799 дугаар шүүгчийн захирамжаар 47,000.0 мянган төгрөг, 2023 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн 131/ШШ2024/00004 дугаар шүүхийн шийдвэрээр 130,000.0 мянга нийт 177,000.0 мянган төгрөгийг хариуцагч Баян-Овоо сумын Засаг дарга, Засаг даргын тамгын газраар төлүүлэхээр шийдвэр гарч тайлант онд Засаг даргын тамгын газар нь 158,240.0 мянган төгрөгийг ШШГГ-ын 230000037952 тоот дансанд төлсөн байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1 “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Баян-Овоо сумын ЗДТГ-ын авлагад бүртгэлтэй байгаа 177,000.0 мянган төгрөгийн авлагыг Захиргааны ерөнхий хуулийн 103.2 “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна” төлүүлж төрийг хохиролгүй болгох албан шаардлагыг Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд хүргүүлэв.

5.1.2 Үндсэн хөрөнгийн тооллогын тооцоо бодсон актаар илүүдэл дутагдал байхгүй гэсэн боловч аудитаар Хадлангийн трактор, Хөрөө рам, малын зөөврийн хашаа зэрэг 31,167.2 мянган төгрөгийн хөрөнгүүд биетээр байхгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5 “Төрийн өөрийн өмчийг зориулалт бусаар захиран зарцуулах, нийгмийн шинжтэй төсөл, арга хэмжээнд зарцуулах, хандив, тусламж, түүнтэй адилтгах хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглох бөгөөд энэхүү хориглолтыг зөрчсөн эрх бүхий этгээдийг албан тушаалаас чөлөөлж, учруулсан хохирлыг нөхөн төлүүлнэ” гэсэн заалтыг зөрчиж оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Баян-Овоо сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй тооллогоор дутсан Хадлангийн трактор, хөрөө рам, зөөврийн хашаа зэрэг хөрөнгүүдийг буруутай алба хаагчаар төлүүлж төрийг хохиролгүй болгох албан шаардлагыг хүргүүлэв.

5.2.3 Баян-Овоо сумын ЗДТГ-ын даргын 2024 оны 9 сарын 20 ний өдрийн А/12 дугаар тушаалаар Суурьшлын бүсийн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны төлбөр болох 16,500.0 мянган төгрөгийг шилжүүлэхдээ е-нэхэмжлэлгүй гүйлгээг хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 14 дүгээр зүйлийн 14.3.1 “анхан шатны баримт бүрдүүлэх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтгүй хийсэн 16,500.0 мянган төгрөгийн гүйлгээний Е-нэхэмжлэхийг ГРАНДАМУР ХХК-аар нөхөн шивүүлж анхан шатны баримтыг бүрдүүлэх, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

5.2.4 Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих Шилэн дансны тухай хуулийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 8 гүйлгээний 117,682.1 мянган төгрөгийн орлого зарлагын гүйлгээ, Ерөөл нэмэх ХХК-тай байгуулсан 160,000.0 төгрөгийн гэрээ нийт 277,682.1 мянган төгрөгийн мэдээлэл мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” 6.4.5 дахь “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтыг зөрчиж байна.

Баян-овоо сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан 117,682.1 мянган төгрөгийн 8 мэдээлэл, Ерөөл нэмэх ХХК-тай байгуулсан 160,000.0 мянган төгрөгийн гэрээ нийт 277,682.1 мянган төгрөгийн мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|------------|-----------|-----------------------------------|-----|--------------------------|-----------|------------|-----------|--------------|-----|---------|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| Баянхонгор аймаг дахь Сум Дундын Иргэний Хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 10 дугаар сарын 26-ний өдрийн 131/ШШ2023/000799 дугаар шүүгчийн захирамжаар 47,000.0 мянган төгрөг, 2023 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн 131/ШШ2024/00004 дугаар шүүхийн шийдвэрээр 130,000.0 мянга нийт 177,000.0 мянган төгрөгийг хариуцагч Баян-Овоо сумын Засаг дарга, Засаг даргын тамгын газраар төлүүлэхээр гарсан байна | 1 | 177,000.0 | | | 1 | 177,000.0 | 1 | 177,000.0 | | | | |
| ДҮН | 1 | 177,000.0 | | | 1 | 177,000.0 | 1 | 177,000.0 | 0 | 0 | 0 | 0 |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|--|-------------|----------|---------------|-----|-----------------|----------|---------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|
| | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Үндсэн хөрөнгийн тооллогын тооцоо бодсон актаар илүүдэл дутагдал байхгүй гэсэн боловч Хадлангийн трактор, Хөрөө рам, малын зөөврийн хашаа зэрэг 31,167.2 мянган төгрөгийн хөрөнгүүд биетээр тоологдоогүй дутсан байна. | 1 | 31,167.2 | | | 1 | 31,167.2 | | | | | | |
| Баян-Овоо сумын ЗДТГ-ын даргын 2024 оны 9 сарын 20 ний өдрийн А/12 дугаар тушаалаар Суурьшлын бүсийн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны төлбөр болох 16,500.0 мянган төгрөгийг | 1 | 16,500.0 | | | 1 | 16,500.0 | | | | | | |

Баян-овоо сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | | | | | | | | | | |
|---|---|-----------|--|--|---|-----------|---|---|---|---|---|---|
| шилжүүлэхдээ е-нэхэмжлэлгүй гүйлгээг хийсэн байна. | | | | | | | | | | | | |
| Шүүхийн шийдвэрт тусгагдсан нийт 177,000.0 мянган төгрөг Засаг даргын тамгын газрын дансанд орж ирээгүй, төсвөөс гадуур зарцуулагдсан, ямар эх үүсвэрт зарцуулсан тодорхойгүй | 1 | 177,000.0 | | | 1 | 177,000.0 | | | | | | |
| Дүн | 3 | 224,667.7 | | | 3 | 224,667.7 | 0 | - | 0 | 0 | 0 | 0 |

7. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|-------------|-----------|---------------|-----|-----------------|-----------|---------|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил | | | | | | | | |
| 6.4.5 "Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ"-д заасан 10 гүйлгээний 356,682.1 мянган төгрөгийн орлого зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна. Мөн Ерөөл нэмэх ХХК-тай 2024 оны 10 дугаар сарын 28-ний өдөр байгуулсан 160,000.0 мянган төгрөгийн гэрээг мэдээлээгүй байна. | 1 | 277,682.1 | | | 1 | 277,682.1 | | |
| Дүн | 1 | 277,682.1 | | | 1 | 277,682.1 | | |

-----oOo-----